



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/167

Мандалговь

「Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх, оролцоог」
хангах орон тооны бус зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.а, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хангаж хэрэгжүүлэх, хамгаалахтай холбогдсон үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх оролцоог хангах орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Зөвлөлийн дарга: Сумын орлогч дарга

Нарийн бичгийн дарга: Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан
мэргэжилтэн

Гишүүд: Сумын нийгмийн бодлогын мэргэжилтэн

Сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэний холбоо төрийн
бус байгууллагын тэргүүн

Сумын эрүүл мэндийн төвийн дарга

Эрдмийн далай цогцолбор сургуулийн нийгмийн

ажилтан

Хүмүүнлэг сургуулийн нийгмийн ажилтан

8-р цэцэрлэгийн арга зүйч

Мандал багийн Засаг дарга

2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах хууль тогтоомжийн талаар, төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр арга хэмжээг орон нутгын хэмжээнд зохицуулан, төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг хангаж ажиллахыг зөвлөлийн нарийн бичгийн дарга (Ч.Сэржмядаг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.БАТ-ОРГИЛ

